

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН 2022 ОНЫ ҮЗҮҮЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны 02 дугаар сарын 27

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилтот түвшин, суурь түвшингийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2.1-т заасан арга зүйгээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ ирүүлсэн тайлангаас гадна статистик мэдээлэлтэй тулган үзэж хийсэн болно.

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН -ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН ОНЦЛОХ АЖЛУУД:


Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссаны дагуу удирдамж батлуулж, аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний нийт 23 агентлаг, 15 сумдаар явцын болон гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд анхаарч ажиллах талаар зөвлөн туслах ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Ингэснээр аймгийн 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт 82,3 хувьтай байгаа нь өмнөх онтой харьцуулахад 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сумдын болон хэлтэс агентлагийн жилийн эцсийн ажлыг дүгнэх 9-11 үзүүлэлтэд салбар тус бүрийн онцлогт нийцүүлэн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг тусгай аргачлалын дагуу тооцож үнэлгээний биелэлтэд хамааруулан дүгнэсэн нь хэрэгжилтэд ахиц өөрчлөлт гарахад түлхэц боллоо.

ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


2022 оны хувьд боловсрол, соёлын салбарын төрийн байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбоотой нийт орлогын дүн бууралттай байна. Төсвийн зарлагын хувьд өр авлагагүй ажилласаар ирсэн.



Ажиллах хүчний оролцооны хувь өмнөх оноос буурсанч 2022 оны зорилтот түвшиндээ хүрсэн, Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2.4 хувиар, ажилгүйдлийн түвшин 4.3 хувиар буурсан сайн үзүүлэлттэй байна.




Болих




Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэгээ нэмэгдүүлсэн бөгөөд мөн эргэн төлөлтийг 2 дахин төвлөрүүлэн ажилласан.

ХЭД сангаас олгогдсон санхүүгийн дэмжлэг болон эргэн төлөлт



Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь, болон жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн хувиуд өмнөх оноос өсч 2022 оны зорилтот түвшиндээ хүрээд байна.


Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтын хувь өмнөх оноос нэмэгдсэн байна.



Хураан авсан хүнсний ногоо, малын тэжээл өмнөх оноос нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



2022 онд Дундговь аймагт гадаад, дотоодын 39914 нь аялагч, жуулчид ирсэн.




2022 оны байдлаар 1307 өрх инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдарч байна. Энэ нь аймгийн нийт өрхийн 8,8 хувийг эзэлж байна.




Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын тоо, цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын хувь зэрэг үзүүлэлтүүд 2022 оны хүрэх түвшиндээ хүрсэн байна.

НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ


Дундговь аймгийн хүн амын дундаж наслалт жилээс жилд нэмэгдэн улсдаа тэргүүлж байна.



Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшинг цагдаагийн газрын нөхөн төлүүлэлт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нөхөн төлүүлэлтийн дундажаар гаргасан.



Жендерийн тэгш бус байдлын индекс өмнөх жилээс өссөн үзүүлэлттэй байна.



Боловсролын салбарт сургуулийн өмнөх боловсрол суурь боловсролын хамран сургалт, бага ангийн нэг багшид ноогдох хүүхдийн тоо, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо зэрэг үзүүлэлт тухайн жилд хүргэх зорилтдоо хүрч биелсэн.



Тухайн жилийн товлот дархлаажуулалтын хувь, артерийн даралт, чихрийн шижин өвчний илрүүлэг, хорт хавдрын эрт илрүүлэг, эхийн эндэгдэлгүй байх үзүүлэлтийн зорилтууд 2022 оны зорилтот түвшиндээ хүрсэн.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт “И-Монголиа” төрийн үйлчилгээний төвийг шинээр байгуулан иргэдэд 487 төрлийн төрийн үйлчилгээг цахимаар үзүүлж байна.



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ


Аймгийн 2022 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 82,3 хувьтай байгаа өмнөх жилээс 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сум, агентлагуудад хамаарах эдийн засаг, нийгмийн хөгжлийн голлох үзүүлэлтүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг жилд 2 удаа хийж, ажил эрчимжүүлэх зөвлөмж өгсний үр дүнд иргэдэд хүрэх мэдээ мэдээллийн хүртээмж нэмэгдэж, ажлын чанар, гүйцэтгэл сайжирч байгаа нь сайшаалтай байна.

Эдийн Засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтээс 2022 оны зорилтот түвшиндээ хүрээгүй 7 үзүүлэлт байна.

Тус аймгийн гол эдийн засгийн салбар нь Хөдөө аж ахуй тэр дундаа мал аж ахуй байдаг ба малын тоо өмнөх оноос 15,3 хувиар буурсан нь дотоодын нийт бүтээгдэхүүн болон нэг хүнд ногдох дотоод нийт бүтээгдэхүүн 2021 оны гүйцэтгэлээр буурахад голлох нөлөөг үзүүлсэн.

Малын тоо жилээс жилд буурч байгаа нь малчид малын тоо бус чанарт ихээхэн анхаарах болсонтой холбоотойгоор малыг зах зээлд ихээр борлуулж байна.



2022 онд долларын ханш өсөж, төгрөгийн ханш унасны улмаас өргөн хэрэглээний барааны үнэ өссөнтэй холбогдуулан хэрэглээний үнийн индекс өмнөх оноос өссөн гэж үзэж байна.

Аймгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өнгөрсөн оноос 2-оор нэмэгдсэн. Энэ нь цахим гэмт хэрэг өссөнөөс шалтгаалж байна.

Нялхсын эндэгдэл 11,8 промилль байгаа нь 2021 оноос 2,2 промилиор буурч улс аймгуудын дундажаас доогуур үзүүлэлтэй байгаа хэдий ч 2022 оны зорилтот түвшиндээ хүрээгүй нь 0-6 хоногтой эрт үеийн нярайн эндэгдэл өссөнтэй холбоотой байна.

Вируст гепатитын өвчлөл нэмэгдсэн нь 2022 оны 5 дугаар сараас улсын хэмжээнд “Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношлогоо” хийгдэж эхэлсэн тул эрт илрүүлэг үзлэг, шинжилгээгээр илрүүлж буйтай холбоотой байна.

Цэцэрлэгийн барилгын хүртээмжгүй байдлаас шалтгаалан бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 29.7 болж нэмэгдсэн.

Аймгийн бодлого болосвруулахдаа эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол үзүүлэлтүүдээр хэмжих ажлыг зохион байгуулж, цаашид ажил дүгнэх үзүүлэлтэд оруулан тооцон эдийн засгийн үзүүлэлтүүдийн хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Аймгийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг 2020 онд ЗГХЭГ-аас ирүүлсэн 45 үзүүлэлтээс 42 –т нь 2020 оны суурь түвшинг тодорхойлж, 2021-2024 онд тухайн үзүүлэлтийг хангах зорилтот түвшингээ хэлэлцэн тодорхойлж 2020.12.17-ны өдөр аймгийн Засаг даргаас 1/1487 тоот албан бичгийн хамт хүргүүлсэн байдаг.

Дээрх үзүүлэлтүүдийн суурь түвшин, зорилтот түвшинг тодорхойлохдоо статистик мэдээлэл болон салбарын мэдээлэлд үндэслэн хийсэн боловч зарим үзүүлэлтийн өсөлт бууралтыг алдаатай хийсэн нь тайлагнах явцад гарч байгаа нь үр дүнг тооцоход бэрхшээл үүсч байгаа тул дахин нягтлан үзэж шинэчлэх шаардлагатай байна.

Байгууллага бүр аливаа дэвшүүлсэн зорилт, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төлөвлөхдөө эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол үзүүлэлтийг авч суурь түвшинтэй уялдуулж, зорилтот түвшинг бодитой төлөвлөх, хэрэгжилтийг үнэн зөв тооцох, тайлагнах үйл ажиллагааг тогтмолжуулах шаардлагатай.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Бодлогын хэлтсүүдэд

1. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг хяналтадаа авч, үзүүлэлтийн биелэлтийг тооцох, тайлагнахдаа тоон мэдээллийг статистик мэдээлэлтэй тулган үнэн зөв бодитой тайлагнах
2. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан сум, агентлагуудын эдийн засгийн үзүүлэлтүүдийг шинэчлэх

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС